



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/188/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Шинжээч Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.23 № 01/23
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
С.ГАНЗОРИГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан байна. Тус байгууллага нь 2023 оныг "Түүхт ойн бүтээн байгуулалтыг дэмжих" урианы жил болгон зорилтоо тодорхойлон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 47 зорилт 187 арга хэмжээтэйгээр төлөвлөн, 86,3 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	73,848,023.41	217,467,708.10
33	АВЛАГА	2,078,653.51	134,860,500.00
335	Бусад авлага	2,078,653.51	134,860,500.00
3351	Байгууллагаас авах авлага	78,653.51	132,400,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,000,000.00	2,460,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	71,769,369.90	82,607,208.10
354	Хангамжийн материал	49,541,394.90	64,759,308.10
35410	Бичиг хэргийн материал	1,748,917.00	1,128,410.00
35420	Аж ахуйн материал	533,500.00	533,500.00
35440	Түлш, шатах тослох материал	3,086,108.90	4,217,261.10
35450	Барилгын засварын материал	1,157,600.00	4,072,100.00
35470	Бусад хангамжийн материал	43,015,269.00	54,808,037.00
35600	Мал амьтад	00.00	5,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,998,825,236.92	2,317,268,536.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,998,825,236.92	2,317,268,536.38
392	Биет хөрөнгө	1,446,429,181.44	1,756,757,147.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,141,715,384.58	1,272,979,431.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	-264,272,688.11	-399,403,282.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	344,430,278.00	400,820,278.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-187,096,172.83	-231,429,524.07
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	211,485,640.30	241,534,283.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	-63,566,859.96	-79,154,707.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	78,496,117.10	82,283,618.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	-58,208,937.73	-63,673,051.14
39209	Зам, гүүрийн байгууламж	1,063,506,328.00	1,063,506,328.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-1,054,545,548.68	-1,056,648,152.68
39214	Бусад үндсэн хөрөнгө	370,819,838.00	693,623,221.90
39215	Хуримтлагдсан элэгдэл	-137,377,597.23	-168,724,696.15
39217	Ном	1,043,400.00	1,043,400.00
393	Биет бус хөрөнгө	552,396,055.48	560,511,388.77
39301	Програм хангамж	1,645,000.00	6,395,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,196,944.52	-1,483,611.23
39303	Бусад биет бус хөрөнгө	577,256,000.00	580,930,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-25,308,000.00	-25,330,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,072,673,260.33	2,534,736,244.48
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,072,673,260.33	2,534,736,244.48
51	Засгийн газрын хувь оролцоо	2,072,673,260.33	2,534,736,244.48
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,009,750,503.06	1,009,750,503.06
51101	Өмч: - төрийн	1,009,750,503.06	1,009,750,503.06
512	Хуримтлагдсан үр дүн	836,015,348.44	1,298,078,332.59
51210	Өмнөх үеийн үр дүн	836,015,348.44	836,015,348.44
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	462,062,984.15
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	226,907,408.83	226,907,408.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,072,673,260.33	2,534,736,244.48

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,592,918,273.18	1,680,521,007.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	944,000,156.18	351,497,260.90
120	Нийтлэг татварын бус орлого	944,000,156.18	351,497,260.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	648,918,117.00	1,329,023,747.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	95,397,817.00	254,963,547.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,507,602.00	251,043,697.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	88,890,215.00	3,919,850.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	553,520,300.00	1,074,060,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	553,520,300.00	1,074,060,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	797,963,868.69	1,224,573,023.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	797,963,868.69	1,209,045,223.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	711,272,475.72	1,110,276,985.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,740,682.00	506,092,503.01
210101	Үндсэн цалин	157,741,844.00	344,263,301.00
210102	Нэмэгдэл	32,158,689.00	118,617,375.89
210104	Урамшуулал	13,840,149.00	43,211,826.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,811,307.32	61,947,935.70
210201	Тэтгэврийн даатгал	18,663,825.98	42,157,104.50
210202	Тэтгэмжийн даатгал	2,100,863.41	4,911,801.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,657,169.26	3,967,701.00
210204	Ажилгүйдлийн даатгал	397,256.83	991,974.60
210205	Эрүүл мэндийн даатгал	3,992,191.84	9,919,354.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,892,356.15	52,114,117.36
210301	Гэрэл, цахилгаан	9,382,744.00	15,310,180.53
210302	Түлш, халаалт	40,509,612.15	36,803,909.83
210303	Цэвэр, бохир ус	00.00	27.00
2104	Хангамж, бараа материалын зардал	62,664,211.74	52,871,661.24
210401	Бичиг хэрэг	5,293,086.00	4,967,520.00
210402	Тээвэр, шатахуун	11,515,303.00	11,308,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,244,600.00	1,796,550.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	43,346,882.74	34,799,591.24
210408	Бараа материал акталсны зардал	1,264,340.00	00.00
2106	Эд хопшил, урсгал засварын зардал	4,420,600.00	15,529,240.60
210604	Урсгал засвар	4,420,600.00	15,529,240.60
2107	Томилот, зочны зардал	3,928,900.00	5,676,000.00
210702	Дотоод албан томилот	3,928,900.00	5,676,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,676,369.97	6,458,324.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	66,347,084.97	5,646,908.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	245,025.00	396,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	365,260.00	288,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	126,016.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	292,138,048.54	409,587,203.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	134,075,025.49	161,579,062.61
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	158,063,023.05	248,008,140.79

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,691,392.97	98,768,238.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,509,247.00	62,991,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,852,700.00	62,991,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	656,547.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	76,182,145.97	29,721,024.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,182,145.97	29,721,024.54
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	6,055,413.70
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,055,413.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	15,527,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	15,527,800.00
221001	Их засвар	00.00	6,772,100.00
223001	Бусад хөрөнгө	00.00	8,755,700.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	794,954,404.49	455,947,984.15
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	6,205,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	00.00	6,205,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	90,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	90,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	6,115,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	794,954,404.49	462,062,984.15

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	648,918,117.00	1,334,768,247.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	648,918,117.00	1,334,768,247.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	95,397,817.00	260,708,047.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,507,602.00	251,043,697.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	88,890,215.00	9,664,350.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	553,520,300.00	1,074,060,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	553,520,300.00	1,074,060,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	487,939,125.06	1,061,769,909.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	487,939,125.06	1,061,769,909.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	553,274,524.03	963,001,670.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,740,682.00	506,092,501.01
210101	Үндсэн цалин	157,741,844.00	344,263,301.00
210102	Нэмэгдэл	32,158,689.00	118,617,373.89
210104	Урамшуулал	13,840,149.00	43,211,826.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,811,307.32	61,995,811.70
210201	Тэтгэврийн даатгал	18,663,825.98	42,157,104.50
210202	Тэтгэмжийн даатгал	2,100,863.41	4,959,677.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,657,169.26	3,967,701.60
210204	Ажилгүйдлийн даатгал	397,256.83	991,974.60
210205	Эрүүл мэндийн даатгал	3,992,191.84	9,919,354.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,401,975.00	52,657,899.56
210301	Гэрэл, цахилгаан	9,382,744.00	11,554,975.81
210302	Түлш, халаалт	40,019,231.00	41,024,923.75
210303	Цэвэр, бохир ус	00.00	78,000.00

2104	Хангамж, бараа материалын зардал	55,019,777.71	54,846,198.84
210401	Бичиг хэрэг	1,198,800.00	1,958,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,420,978.00	11,477,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,989,850.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	41,199,999.71	39,420,648.84
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	2,300,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	2,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,988,700.00	5,676,000.00
210702	Дотоод албан томилолт	2,988,700.00	5,676,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,186,306.00	6,851,076.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,113,021.00	5,719,660.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	320,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	254,025.00	309,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	356,260.00	393,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	107,916.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	144,625,776.00	272,582,183.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	144,625,776.00	272,582,183.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,028,892.97	98,768,238.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,846,747.00	62,991,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,852,700.00	62,991,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	994,047.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	76,182,145.97	29,721,024.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,182,145.97	29,721,024.54
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	6,055,413.70
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,055,413.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,614,700.00	272,998,337.95
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,614,700.00	272,998,337.95
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,614,700.00	272,998,337.95
2200	Дотоод эх үүсвэрээр	8,614,700.00	272,998,337.95
221001	Их засвар	00.00	41,956,690.60
223001	Бусад хөрөнгө	00.00	9,438,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,614,700.00	221,603,447.35
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-8,614,700.00	-272,998,337.95
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,009,750,503.06	226,907,408.83	836,015,348.44	00.00	2,072,673,260.33
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,009,750,503.06	226,907,408.83	836,015,348.44	00.00	2,072,673,260.33
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,009,750,503.06	226,907,408.83	836,015,348.44	00.00	2,072,673,260.33
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	462,062,984.15	00.00	462,062,984.15
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,009,750,503.06	226,907,408.83	1,298,078,332.59	00.00	2,534,736,244.48

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,322,358,100.00	1,050,441,025.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,030,278,500.00	800,092,687.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	967,286,700.00	737,100,887.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	472,027,900.00	471,390,301.92
210101	Үндсэн цалин	418,025,100.00	338,662,898.65
210102	Нэмэгдэл	54,002,800.00	91,048,752.15
210104	Урамшуулал	00.00	41,678,651.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,003,600.00	59,003,600.00
210201	Тэтгэврийн даатгал	40,122,400.00	40,122,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,720,300.00	4,720,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,776,200.00	3,776,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	944,100.00	944,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,440,600.00	9,440,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,657,900.00	52,657,899.56
210301	Гэрэл, цахилгаан	11,065,300.00	11,554,975.81
210302	Түлш, халаалт	41,492,600.00	41,024,923.75
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	78,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	55,272,700.00	54,283,198.84
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	1,958,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,872,700.00	10,914,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	1,989,850.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, а	40,000,000.00	39,420,648.84
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,300,000.00	2,300,000.00
210604	Урсгал засвар	2,300,000.00	2,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,685,200.00	5,676,000.00
210702	Дотоод албан томилолт	5,685,200.00	5,676,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	10,666,500.00	10,461,166.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгэ	9,500,000.00	9,329,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	320,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	309,700.00	309,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	393,800.00	393,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	107,916.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	309,672,900.00	81,328,721.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	309,672,900.00	81,328,721.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62991800.00	62991800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,991,800.00	62,991,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэм	62,991,800.00	62,991,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	292,079,600.00	250,348,337.95
2200	Дотоод эх үүсвэрээр	292,079,600.00	250,348,337.95
221001	Их засвар	175,000,000.00	133,269,237.95
222001	Тоног төхөөрөмж	15,000,000.00	14,999,500.00
223001	Бусад хөрөнгө	102,079,600.00	102,079,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,322,358,100.00	1,074,060,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,322,358,100.00	1,074,060,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	1,322,358,100.00	1,074,060,200.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	95,397,817.00	248,550,783.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	95,397,817.00	248,550,783.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	95,397,817.00	248,550,783.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		34,702,199.09
210101	Үндсэн цалин		5,600,402.35
210102	Нэмэгдэл		27,568,621.74
210104	Урамшуулал		1,533,175.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,992,211.70
210201	Тэтгэврийн даатгал		2,034,704.50
210202	Тэтгэмжийн даатгал		239,377.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		191,501.60
210204	Ажилгүйдлийн даатгал		47,874.60
210205	Эрүүл мэндийн даатгал		478,754.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,809,378.00	563,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,809,378.00	563,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,		1,139,910.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний		1,139,910.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,588,439.00	209,153,462.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	93,588,439.00	209,153,462.50
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	95,397,817.00	260,708,047.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	95,397,817.00	260,708,047.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,369,602.00	251,043,697.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,028,215.00	9,664,350.00
IV	НИИТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын эрхэм зорилго нь төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, төрийн захиргааны ажлыг тогтвортой, чанартай стандартын дагуу явуулж үр дүнд хүргэхэд чиглэсэн.

Тус сум нь 2023 оны “Түүхт ойн бүтээн байгуулалтыг дэмжих” урианы жил болгон зорилтоо тодорхойлон ЗДТГ-ын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 47 зорилт 187 арга хэмжээтэйгээр төлөвлөн, 86,3 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналтын ажлын хэсэг тайлант онд хяналт шалгалт хийгээгүй. Харин аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт аудитын алба нь 2021, 2022 оны санхүүгийн баримтад шалгалт хийсэн байна.

Мөн завсрын аудитыг 2023 оны эхний 9 сарын байдлаарх санхүүгийн баримтад хийж, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг асуудлын бүртгэлээр танилцуулсан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2013 онд хэвлэгдсэн ба шинээр гарсан хууль тогтоомж заавар журмаар баяжуулан хэрэглэж байна. Аймгийн СТСХ-с нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нэгдсэн журмаар боловсруулж өгөх чиглэл өгсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад бүрэн нийцэхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 462,063.0 мянган төгрөгөөр буюу 22,3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	2,078.60	134,860.5	132,781.9
Бараа материал	71,769.40	82,607.2	10,837.8
Үндсэн хөрөнгө	1,998,825.20	2,317,268.5	318,443.3
Нийт хөрөнгө	2,072,673.20	2,534,736.2	462,063.0
Өр төлбөр			0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,072,673.20	2,534,736.2	462,063.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,072,673.20	2,534,736.2	462,063.0

Дээрх хүснэгтээс харахад авлага дансны үлдэгдэл 134,860.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 132,781.9 мянган төгрөгөөр өссөн нь байна. Үүнд:

- Аймгийн хөрөнгө оруулалтын зардлаас Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах төсөл арга хэмжээний эрх шилжиж ирсэн 100,000.0 мянган төгрөгөөс Монголиа Дижитал Скүүл ХХК-д 2023 оны 12 дугаар сарын 24-ны өдөр 60,000.0 мянган төгрөгийг шилжүүлж, барилга байгууламж дансанд орлогоор бүртгэсэн, үлдэгдэл 40,000.0 мянган төгрөгийг сумын ОНХС-д шилжүүлж зардлаар тайлагнасан алдааг аудитын явцад залруулж, авлагаар бүртгэсэн.
- Батсүмбэр сумын Засаг даргын 2023 онын А/719 захирамжаар Инженер геодези ХХК-д сумын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын урьдчилгаа 50 хувь болох 24,900.0 мянган төгрөгийг, Баялаг фийд ХХК-д тэжээлийн үнэд 7,500.0 мянган төгрөг тус тус шилжүүлж авлагаар бүртгэсэн.
- Оны эхний үлдэгдэл 2,000.0 мянган төгрөг нь 2021 онд булгийн эхийг хаших зориулалтаар олгосон авлага барагдаагүй зэргээс шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 82,607.2 мянган төгрөг болж, 10,837.8 мянган төгрөгөөр өссөн нь барилгын засварын материалын үлдэгдэл тайлант хугацааны эцэст бэлтгэснээс 4,072.1 мянган төгрөгөөр өссөн, ОНХС-гийн эх үүсвэрээр 5,000.0 мянган төгрөгийн 10 толгой эцэг мал бэлтгэснийг мал амьтад дансанд бүртгэсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,317,268.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 318,443.3 мянган төгрөгөөр өссөн. Энэ нь тайлант онд төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 221,603.4 мянган төгрөгийн, ОНХС-ийн болон бусад эх үүсвэрээс 344,938.0 мянган төгрөгийн нийт 566,541.4 мянган төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэж, сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 57 тоот тогтоолоор авто тээврийн хэрэгслийн данснаас 4ш багийн дарга нарын мотоцикл 3,600.0 мянган төгрөгөөр, нэр төрлийн тоног төхөөрөмж 10,111.4 мянган төгрөг, 2ш 112.5 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, нийт 13,823.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан ба тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардлыг 248,008.1 мянган төгрөгөөр тооцсонтой холбоотой байна.

Эздийн өмч 2,534,736.2 мянган төгрөг болж 462,063.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,008,749.1 мянган төгрөг, нийт зарлагыг 1,008,749.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 313,609.0 мянган төгрөгөөр өсгөж, урсгал зардлыг 941,539.2 мянган төгрөгөөр, орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг 268,200.0 мянган төгрөгөөр буюу 1,209,739.2 мянган төгрөгөөр баталсан байна

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 112,618.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 03 тоот тогтоолоор 1,322,358.1 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,322,358.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн орлогоос 1,074,060.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 271,917.1 мянган төгрөгөөр дутуу буюу 79,4 хувьтай хэрэгжсэн байна. Энэ нь батлагдсан зардлын 248,297.9 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлж, зарцуулаагүй үлдэгдэл 23,619.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн хэрэгжилтэд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс 228,041.1 мянган төгрөг дутуу зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-80101 үндсэн үйл ажиллагааны зардал	616,977.6	615,553.4	1,424.2	99,8%
2	70106-80103 гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	0	0		
3	70106-80106 баг хорооны үйл ажиллагааны зардал	9,052.2	9,052.2	0	100%
4	70106-80802 ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	62,991.8	62,991.8	0	100%
5	70106-80918 бусад	292,079.6	250,348.3	41,731.3	85.7%
6	70106-81102 орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	5,000.0	0	100%
7	70106-82801 улсын их баяр наадам	5,000.0	4,858.9	141.1	97.2%
8	71411-81701 байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	291,256.9	63,215.8	228,041.1	21.7%
9	71411-82212 хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	40,000.0	39,420.6	579.3	98.6%
	Дүн	1,322,358.1	1,050,441.0	271,917.1	79,5%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд тайлант хугацаанд 260,708.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 248,550.8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 12,157.3 мянган төгрөгийг аймгийн төсөвт 6,055.4 мянган төгрөгийг, сумын төсөвт 6,101.8 мянган төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хагас жилийн мал тооллогын зардал 1,634.2 мянган төгрөг, зөвлөлдөх санал асуулгын шатахууны зардал 113.0 мянган төгрөг, судалгааны зардал 1,590.0 мянган төгрөг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал 1,000.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөцөөс урамшуулал 800.0 мянган төгрөг, гэрэл цахилгааны өглөгт 1,187.4 мянган төгрөг, Орон нутгийн нэмэгдэлд 43,7961 мянган төгрөг, шилдэг багийн урамшуулал 1,000.0 мянган төгрөг, тендер хураамж 1,470.0 мянган төгрөг, Эрчим хүчний хангамжийн эх үүсвэрийн хүчин чадал сайжруулах 99,923.0 сая төгрөг, Төрийн албан хаагчийн орон сууцаар хангах хөтөлбөрийн санхүүжилт 100,000.0 сая төгрөг, Хорголжин тэжээлийн үнэ 5,744.5 мянган төгрөг, өвс боосон хөлс 1,849.8 мянган төгрөг, бусад нэмэлт орлого 600.0 мянган төгрөг бүгд 260,708.0 мянган төгрөгийн орлого тайлагнасан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106 орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023	Төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэж, иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ.	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 86,3 % , сумын 2023 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 82,5%, төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт 83,0% төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр 95 %-тай хэрэгжсэн	991,101.2	947,804.6
2	71411 хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2023	Хог хаягдлын хураамжийн төлөвлөгөөг 100% ханган биелүүлж, хог хаягдлыг тогтмол цэвэрлэн хур хог хаягдал үүсгэлгүй ажиллана.	2023 онд иргэн, ААНБ-с нийт 22,5 мянган төгрөгийн хог хаягдлын хураамжийн орлого төвлөрүүлсэн.	331,256.9	102,636.4
ДҮН					1,322,358.1	1,050,441.0

Тайлант онд хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн хэрэгжилт 31,0 хувьтай байгаа нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар санхүүжилт оройтсоноос 22 ажил төлөвлөснөөс 63,215.8 мянган төгрөгийн 10 ажил гүйцэтгэсэн. Иргэд болон аялагчид ихээр ирж хог хаягдал үүсгэж байгаагаас болж хог хаягдал цэвэрлэх, ачихад хүндрэлтэй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Батсүмбэр сумын ЗДТГ нь тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг шилэн дансанд байршуулаагүй байна. Нээлттэй тендер шалгаруулалтаар 60,000.0 мянган төгрөгийн хог тээврийн машин, 100,000.0 мянган төгрөгийн тамгын газрын гадна фасадын их засвар, 50,000.0 мянган төгрөгийн сумын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах төсөл арга хэмжээг гүйцэтгэгч байгууллагыг шалгаруулсан байна. Хангамжийн материал болон тогтмол зардлыг харилцагч байгууллагуудтай шууд гэрээ байгуулан гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт шинжээч Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06/11 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүү үр дүнгийн тайлангийн 1,264,539.7 мянган төгрөгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг үзүүлэлтээр Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүү үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,264,539.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 18,968.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 14,226.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүйгээс, зарцуулаагүй үлдэгдэл 23,619.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд байршуулах 176 мэдээллээс худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг байршуулаагүй, нэг мэдээлэл хугацаа хоцроосон төлөвтэй байна. Шилэн дансанд Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 32 орлогын мөнгөн гүйлгээ, Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 24 зарлагын мөнгөн гүйлгээ, Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 37 шийдвэрийн мэдээллийг байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын эхний 9 сарын байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн байна. Аудитаар бичигдсэн төлбөрийн актыг барагдуулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллагад 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 600.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 9,000.0 мянган төгрөгийн албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, фас системд мэдээллийг оруулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	600.0	1	600.0	100
Албан шаардлага	1	9,000.0	1	9,000.0	100
Зөвлөмж	1	0	1	0	
Нийт дүн	3	9,600.0	3	9,600.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын дараагийн аудитаар Си Ти Эс ХХК-д санхүүгийн программын үнэнд 1,750.0 мянган төгрөг, Ухаалаг засаглал Нү ТББ-д шилжүүлсэн 3,000.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим программын ашиглалт үр дүнд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,360,533.6 мянган төгрөгийн гурван алдаа¹ илэрснээс аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн тайланд цалингийн урьдчилгаа 550.2 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

2. Төрийн албан хаагчдын орон сууцаар хангах хөтөлбөрийн санхүүжилт эрх шилжиж ирсэн 100,000.0 мянган төгрөгөөс Монголиа Дижитал Скүүл ХХК-д сумын Засаг даргын 2023 оны А/731 дугаар захирамжаар 2023 оны 12 дугаар сарын 24-ны өдөр 60,000.0 мянган төгрөгийг шилжүүлж, барилга байгууламж дансанд орлогоор бүртгэж тайлагнасан, зарцуулаагүй үлдэгдэл 40,000.0 мянган төгрөгийг сумын ОНХС-д шилжүүлж зардлаар тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "оршин байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

3. Үндсэн хөрөнгийн Зам гүүрний барилга байгууламж дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн гэх Хүйн голын бетон гүүрийг 1,259,983.4 мянган төгрөгөөр хүлээн авсан акт, анхан шатны баримт материалгүйгээр бүртгэж тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар илэрсэн 21,285.4 мянган төгрөгийн зөрчил² -д 12,872.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 8,413.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

5.2 Төлбөрийн акт

1. Дансны эхний үлдэгдэл 2,000.0 мянган төгрөгийн авлага нь 2021 онд булгийн эхийг хаших зориулалтаар олгож, ажлыг гүйцэтгээгүйгээс авлагаар бүртгэсэн 2022, 2023 онд уг ажил хийгдээгүй, авлага барагдаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2. Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн “Төрийн албан хаагчдын ангилал зэрэглэл, цалин хөлсийг шинэчлэн тогтоож, орон нутгийн нэмэгдэл олгох тухай” Б/02 дугаар захирамж, Батсүмбэр сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Төрийн албан хаагчдын ангилал зэрэглэл, цалин хөлсийг шинэчлэн тогтоож, орон нутгийн нэмэгдэл олгох тухай” А/30 дугаар захирамжийн дагуу орон нутгийн нэмэгдлийг 7 улс төрийн албан хаагчид 10,872.2 мянган төгрөг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17-д “Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Батсүмбэр сумын Засаг даргын захирамжаар ЗДТГ-ын ковш тракторын өвлийн техник үйлчилгээний тос масло, маслоны шүүр, гидрийн шингэн, урд хойд олгой, камерын зардалд 2,575.3 мянган төгрөгийг, Прадо-120 автомашины урсгал засварын зардалд 412.5 мянган төгрөгийг, Катын засварт 988.0 мянган төгрөг, катын олгойн үнэнд 700.0 мянган төгрөгийг техникийн комиссын дүгнэлт, нотлох баримтгүйгээр шилжүүлсэн зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна

Өгсөн зөвлөмж

Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний зардлыг байгууллагын техникийн комиссын дүгнэлт шийдвэрийг үндэслэн шилжүүлэх ба засвар үйлчилгээ, материалыг ажлын хэсгээр хүлээн авч, акт хөтөлж хэвших

2. Бараа материалын ашиглалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материал дансанд Ковидын үед бэлтгэсэн 14 нэр төрлийн 3,667.3 мянган төгрөгийн ариутгагч, нэг удаагийн маск, бээлий, халаад, нүүрний хаалт зэрэг нь ашиглалтгүйгээр үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна

Өгсөн зөвлөмж

Бараа, материалын чанар байдал, ашиглах хугацаа зэргийг шалгаж, муудах болон ашиглалтгүй болохоос урьдчилан сэргийлсэн арга хэмжээ авах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу Төв аймаг дахь Төрийн аудитын газарт батлагдсан төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 25-ны дотор, төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн урьдчилгааг туслах үйл- ны орлогоор бүртгэсэн	1	550.2			1	550.2	1	550.2		
ТАХ-ын орон сууцны төлбөрийг хүлээн авсан баримтгүйгэ эр данс бүртгэлд тусгасан болон үлдэгдлийг ОНХС-д шилжүүлсэн	1	100,000.0	1	100,000.0			1	100,000.0		
Хүйн голын бетон гүүрийг хүлээн авсан акт, анхан шатны баримт материалгүй гээр бүртгэсэн	1	1,259,983.4			1	1,259,983.4	1	1,259,983.4		
Дүн	3	1,360,533.6	1	100,000.0	2	1,260,533.6	3	1,360,533.6		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Авлага барагдуулаагүй	1	2,000.0	1	2,000.0								
Дүн	1	2,000.0	1	2,000.0								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Орон нутгийн нэмэгдлийг 7 улс төрийн албан хаагчид олгосон	1	10,872.2	1	10,872.2				
Бараа материал дансанд Ковидын үед бэлтгэсэн материал ашиглалтгүй байна.	1	3,667.3					1	3,667.3
Техникийн комиссын дүгнэлт, нотлох баримтгүйгээр зарцуулсан	1	4,745.9					1	4,745.9
Дүн								
Нийт дүн	3	19,285.4	1	10,872.2			2	8,413.2